



ХЭНТИЙ АЙМАГ  
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 5/07

Өмнөдэлгэр сум

Г М.Сод-Ирээдүйг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 56.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолын 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Хоринзургаа дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 05/2465 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул Мөнхбатын Сод-Ирээдүйг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Талын булаг багийн Засаг даргаар томилсугай.

2.М.Сод-Ирээдүйн үндсэн цалинг 1,458,000 (нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөг, онцгой нөхцөлийн нэмэгдлийг үндсэн цалингийн 30 хувь, орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР



କ୍ଷେତ୍ର ପାଇଁ ଏହାରେ କିମ୍ବା କିମ୍ବା ଏହାରେ କିମ୍ବା ଏହାରେ କିମ୍ବା

2025 02 May 2025

ଚତୁର୍ଦ୍ଦିଶ

ମୋଡ୍ରୋମ୍ ପତ୍ର



କାଳୀ ପାଶରୁ ଏବଂ କରିବାର  
କାଳୀ ପାଶରୁ ଏବଂ କରିବାର